



ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

/2017 оны жилийн эцсийн байдлаар/

2018.01.05

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Зам, тээврийн хөгжлийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, Засгийн газарт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг тайлагнах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгон журмын 6.3-т заасан аргачлалыг баримталсан.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын 7 тогтоолын 13 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 5 тогтоолын 8 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 зөвлөмжийн 4 заалт, Засгийн газрын 96 тогтоолын 131 заалт, Ерөнхий сайдын 3 захирамжийн 3 заалт, Засгийн газрын хуралдааны 86 тэмдэглэлийн 129 заалт буюу нийт 201 шийдвэрийн 310 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан.

Эдгээрээс бүрэн хэрэгжсэн 174, хэрэгжих шатанд байгаа буюу 70%-ийн хэрэгжилттэй 90, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй 23, хэрэгжүүлэх хугацаа болоогүй 16, хүчингүй болсон 6 заалт байгаа бөгөөд хэрэгжилт 84.7%-тай байна. Хангалтгүй хэрэгжиж буй тогтоол, шийдвэрийн жагсаалтыг хавсаргав. /Хавсралт 1/

УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Зам, тээврийн хөгжлийн сайдад үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч, хяналтын хуудас хөтлөн ажиллаж байна. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдалд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн яамны газар, хэлтсийн ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлт болгон ашиглаж байна.

Мөн салбарын хуулиар тусгайлан журам боловсруулж батлахаар эрх олгосон дүрэм, журмын судалгааг гаргаж, яамны холбогдох газар, хэлтэст хүргүүлэн хуульд заасан эрх зүйн акт /дүрэм, журам, заавар, бусад/-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх арга хэмжээ авч ажилласан. Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 05 дугаар сарын 11, Усан замын тээврийн шинэчилсэн найруулга 2017 оны 05 дугаар сарын 25-нд батлагдсантай холбогдуулан эдгээр хуулиудаар эрх зүйн акт /дүрэм, журам, заавар/ батлахаар эрх олгогдсон 24 заалтыг хяналтад авч эдгээр дүрэм, журмыг боловсруулж



батлуулах ажлын хэсгүүд байгуулан ажиллаж байна. Хуулиар журам батлуулахаар эрх олгогдсон 71 заалтын хэрэгжилт 2017 оны жилийн эцсийн байдлаар 83.2 хувьтай байна.


Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн

(2017 оны жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 1

	Бүгд	Үүнээс							
		Улсын Их Хурлын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	ҮАБЗ-ийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	201	7	5	3	96	3	86	1	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	310	24	8	4	131	3	129	11	
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100%	174	8	2	1	78	2	75	8
	Хэрэгжих шатанд 70%	90	10	3	3	34	1	36	3
	Хэрэгжилт хангалтгүй 30%	23	3	3	-	6	-	11	-
	Хэрэгжээгүй	1	-	-	-	-	-	1	-
	Хугацаа болоогүй	16	3			7	-	6	-
	Хүчингүй болсон	6	-	-	-	6	-	-	-
Биелэлтийн дүн /хувь/	84.7	75.7	62.5	77.5	87.8	90.0	84.1	91.8	

Зураг 1



Зураг 2




Холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдлыг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар, хэлтсээр авч үзвэл:

Хүснэгт 2

№	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар, хэлтэс	Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
			100%	70%	30%	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
1	БТГ	126	64	43	9	1	8	1	82.7
2	ТЗУГ	64	41	16	4	-	2	1	87.5
3	ХШУДАГ	35	23	8	-	1	3	-	89.4
4	АЗБХЗГ	69	37	24	1	1	4	2	85.9
5	АТБХЗГ	49	21	21	2	1	4	-	80.7
6	ТЗДТБХЗГ	70	24	26	14	-	2	4	72.5
7	АТБХЗХ	52	20	21	5	2	5	-	75.4
8	ИНЕГ	28	21	4	2	-	1	-	90.4
9	ЗТХТ	15	8	6	-	-	1	-	87.1
10	АТҮТ	15	8	6	-	-	1	-	87.1
11	ГТХЗНТ	14	10	1	-	-	3	-	97.3
12	МИАТ	14	10	3	1	-	-	-	88.6
13	УБТЗ	16	11	3	-	2	-	-	81.9
14	МТЗ	17	13	4	-	-	-	-	92.9
15	Далайн захиргаа	16	7	7	-	-	2	-	85.0
	Нийт	310	174	90	23	1	16	6	84.7

Зураг 3





Гурав. Дүгнэлт

1. 2017 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэгдсэн 24 асуудлаас 13 нь төмөр зам, далайн тээврийн салбарын, 5 нь иргэний нисэхийн салбарын, 1 нь авто замын салбарын, 2 нь авто тээврийн салбарын, 3 нь салбар дундын асуудал байгаа бөгөөд үүнээс 13 асуудал нь хөрөнгө оруулалт, санхүүжилт шийдэгдээгүйгээс удааширч байна.

2. Зам, тээврийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой 4 асуудлын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд 2017 онд батлуулахаар заасан Төмөр замын тээврийн тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Хоолойн тээврийн тухай хуулийн төслийг боловсруулах, "Далайн захиргаа"-ны эрх зүйн байдлыг тодорхой болгох, Тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлаар холбогдох хуулийн төсөл боловсруулах, "Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн сан"-д хуримтлагдсан хөрөнгийг зарцуулах эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлууд удаашралтай байна.

3. Гадаад зээллэгийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээл тус бүрийг үнэлэх, мөн зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зэрэг зөрчилтэй зээлүүдийг эргэн төлүүлж, үүссэн авлагыг барагдуулах, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зардлыг багасгах, тэдгээрт ажиллагсдын тоог бууруулан 2012 оны түвшинд хүргэх, Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр байгуулсан шилэн кабелийн сүлжээг төрийн мэдэлд шилжүүлэх, Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос тус аймгийн Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачиж, буулгах терминалын хамт төрийн өмчит "Монголын төмөр зам" ХХК-ийн өмчид шилжүүлэн авах, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2017-2018 оны улсын хэлэлцээрт үндэслэн салбарын түвшинд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн хэлэлцээр байгуулах, УБ хотын олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаа, төслийн зээлийн захиран зарцуулалтад хяналт шалгалт хийх хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үр дүн, дүгнэлт, саналаа 2017.10.15-ны дотор ЗГ-т танилцуулах, Хот хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагааг улсын хэмжээнд хариуцаж байгаа АТҮТ ТӨҮГ-ын чиг үүрэгтэй давхацсан чиг үүрэгтэй, үр ашиггүй орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар байгуулсан шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авах зэрэг санхүүжилт шаардагдахгүй, шийдвэрлэх боломжтой ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна.

4. Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нислэгийн хөдөлгөөнд үйлчлэх зориулалттай нэгдмэл системийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон нисэх буудлуудын барилга байгууламж, холбогдох бусад эд хөрөнгө, бичиг баримтыг "Иргэний нисэхийн үндэсний корпораци" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлэх, "Иргэний нисэхийн үндэсний корпораци" ТАААТҮГ байгуулах ажлыг шуурхай зохион байгуулах зэрэг хэрэгжих боломжгүй болсон, бодлого төлөвлөлт нь өөрчлөгдсөн заалтуудыг хүчингүй болгох шаардлагатай байна.

5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2017 оны 08 сарын 21-ний өдрийн ЗТХС-ын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, эхний хагас жилийн байдлаар тасарсан болон хэрэгжилт удааширсан шийдвэрийг хэрэгжүүлэх 4 дүгээр тэмдэглэл гаргасан. Хуралдааны шийдвэрийг



хэрэгжүүлэх талаар газар, хэлтсүүд анхаарч, холбогдох мэргэжилтнүүдэд хугацаатай үүрэг, даалгавар өгч ажилласны дүнд 2017 оны эхний хагас жилийн байдлаар тогтоол шийдвэрийн хэрэгжилт 76,8%-тай байсан бол жилийн эцсийн байдлаар 84.7% болж өссөн дүнтэй байна.

6. Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар эрх зүйн акт /дүрэм, журам, заавар/ батлахаар эрх олгогдсон заалтуудад заасан дүрэм, журмыг шинэчлэх болон шинээр боловсруулахаар Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар ажлын хэсгүүд байгуулагдсан. Нийт 11 журмын төсөл боловсруулах ажил хийгдэж байна.

7. Усан замын тээврийн шинэчилсэн найруулгад нийт 9 эрх зүйн акт /дүрэм, журам, заавар/ батлахаар эрх олгогдсон. Эдгээрээс 4 журмыг шинэчлэн боловсруулж ирүүлэх тухай 02/3321 тоот албан бичгийг Далайн захиргаанд 7-р сард хүргүүлсэн бөгөөд эдгээр журмуудыг боловсруулахад цаг хугацаа, тооцоо, судалгаа, мэдээлэл шаардлагатай байгаа тул 2018 оны үр дүнгийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Дөрөв. Санал, зөвлөмж:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй байгаа хөрөнгө оруулалт, санхүүжилт шаардагдахгүйгээр шийдвэрлэх боломжтой үүрэг, даалгаврыг ойрын хугацаанд хэрэгжүүлж дуусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах,
2. Хөрөнгө оруулалт, санхүүжилт шийдэгдээгүйгээс удаашралтай байгаа үүрэг, даалгаврыг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж, Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах;
3. Бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүчингүй болгох санал боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх, Төрөөс баримтлах бодлогуудад нэмэлт өөрчлөлт оруулахдаа эдгээртэй холбоотой өмнө гарсан тогтоол, шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөлт оруулах асуудлыг давхар шийдвэрлэх;
4. Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Усан замын тээврийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан эдгээр хуулиудаар эрх зүйн акт /дүрэм, журам, заавар/ батлахаар эрх олгогдсон заалтуудад заасан дүрэм, журмыг шинэчлэх болон шинээр боловсруулах ажлыг эрчимжүүлж, 2018 оны эхний хагас жилд багтаан батлуулах;
5. Тогтоол, шийдвэрийн хяналтын хуудсанд сайд, дэд сайд, ТНБД болон холбогдох газар, хэлтсийн дарга нар хариуцан хэрэгжүүлэх газар, мэргэжилтнийг зааж, тодорхой чиглэл өгсөн цохолт хийж, ТЗУГ тухайн эрх зүйн актаар үүрэг өгөгдсөн байгууллага, албан тушаалтанд албан ёсоор хүргүүлж хэвших;

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ



**Хэрэгжилт хангалтгүй байгаа хууль тогтоомж,
тогтоол шийдвэрийн жагсаалт**

/2017 оны жилийн эцсийн байдлаар/

1.УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
1	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай 2010.06.24 №32	5/ энэ тогтоолын 2 дахь заалтын 4 дэх дэд заалтад заасан чиглэлтэй уялдуулан хөндлөн болон баруун босоо чиглэлд тавих төмөр замын замнал /маршрут/-ыг нарийвчлан тодорхойлж Улсын Их Хуралд танилцуулах;	ТЗДТБХЗГ
2	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016.11.17 №69	3.Гадаад зээллэгийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээл тус бүрийг үнэлэх, мөн зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зэрэг зөрчилтэй зээлүүдийг эргэн төлүүлж, үүссэн авлагыг барагдуулах;	БТГ
		3.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зардлыг багасгах, тэдгээрт ажиллагсдын тоог бууруулан 2012 оны түвшинд хүргэх;	БТГ
2. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ			
3	Хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах асуудлаар чиглэл өгөх тухай 2009.06.17 №04	1. Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамны харьяа байгууллага болох "Далайн захиргаа"-ны эрх зүйн байдлыг тодорхой болгох	ТЗДТБХЗГ
4	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2011.09.09 №35/32	3.Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 3.2.2-т заасан эхний үе шатны төмөр замын суурь бүтцийг мөн бодлогын 3.2.4-т заасан 2 дахь үе шатны төмөр замын суурь бүтцийн хамт 2013 онд багтаан ашиглалтад оруулах;	ТЗДТБХЗГ
		4.Дээрх бодлогын баримт бичгийн 3.2.6-д заасан гуравдугаар үе шатанд барьж эхлэх 3600 орчим км төмөр замын замнал /маршрут/-ыг нарийвчлан тодорхойлж Улсын Их Хуралд танилцуулах.	ТЗДТБХЗГ
3.ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
5	Нийслэлийн нийтийн тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2010.11.23 №303	4. Засгийн газарт танилцуулсны үндсэн дээр энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан санд хуримтлуулсан хөрөнгөөс жил бүр нийтийн зорчигч тээврийн паркийг шинэчлэх арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.	АТБХЗГ
6	Мэдээлэл холбооны сүлжээний давхардлыг арилгах тухай 2013.01.12 №6	2. Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр байгуулсан шилэн кабелийн сүлжээг төрийн мэдэлд шилжүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Жадамбаа, Төрийн өмчийн хороонд даалгасугай.	БТГ ТЗДТБХЗГ
7	"Богдхан" төмөр зам болон "Улаанбаатар" холимог тээврийн ложистик төвийг барьж байгуулах талаар авч	2."Богдхан төмөр зам" болон "Улаанбаатар" холимог тээврийн ложистик төвийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийн асуудлийг АХБ-тай эцэслэн тохиролцож, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан ЗГ-ын	БТГ ТЗДТБХЗГ



	хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2015.03.23 №110	хуралдаанаар хэлэлцүүлэхийг ЗТ-ийн сайд Н.Төмөрхүү, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт даалгасугай.	
8	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай 2015.04.06 №129	3. Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нислэгийн хөдөлгөөнд үйлчлэх зориулалттай нэгдмэл системийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон нисэх буудлуудын барилга байгууламж, холбогдох бусад эд хөрөнгө, бичиг баримтыг "Иргэний нисэхийн үндэсний корпораци" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Төрийн өмчийн хороонд тус тус даалгасугай.	БТГ АТБХЗХ
9	Концессын зүйлийг төрийн өмчид шилжүүлэн авах тухай 2016.02.01 №77	2. Концессын зүйлийг төрийн өмчит "Монголын төмөр зам" ХХК-ийн өмчид шилжүүлэн авах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Б.Болор, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, төрийн өмчит "Монголын төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Мэргэн)-д тус тус даалгасугай. /Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос тус аймгийн Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачиж, буулгах терминалын хамт төрийн өмчит "Монголын төмөр зам" ХХК-ийн өмчид шилжүүлэн авах/	БТГ
4. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ			
10	"Өмнөговь аймгийн Засаг даргын мэдээлэлтэй холбогдуулан холбогдох арга хэмжээ авч ажиллах тухай" 2011.05.25 №26	1.4 Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд тусгагдсан Мандалговь-Даланзадгад чиглэлийн 163 км, Даланзадгад-Оюутолгой чиглэлийн 251 км хатуу хучилттай авто замын ажлын явцыг түргэтгэх, "Гурвансайхан" онгоцны буудлыг өргөтгөх асуудлыг судалж шийдвэрлэх	БТГ АЗБХЗГ АТБХЗХ ИНЕГ
11	"Шинэ төмөр замын төслийн тухай" Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яаманд 2011.08.31 №40	2.2 Техник-эдийн засгийн үндэслэлд тодорхойлсон сүлжээ /Тавантолгой-Цагаан Суварга-Сайшанд- Баруун-урт-Чойбалсан, Хөөт-нөмрөг-Ухаахудаг-Гашуунсухайт, Нарийн сухайт-Шивээхүрэн/-ний дагуу төмөр замын барилгын ажлыг цогц байдлаар хэрэгжүүлэх арга хэмжээ авах	ТЗДТБХЗГ
		2.3 Шинэ төмөр замын техник-эдийн засгийн үндэслэлд цаашид хийгдэхээр тусгагдсан ажлуудыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх	ТЗДТБХЗГ
12	Зам, тээврийн яаманд 2013.09.06 №39	4.4.УБ-Арвайхээр чиглэлийн хот хоорондын хатуу хучилттай авто замын засвар шинэчлэл хийх шаардлагатай 60 км замын асуудлыг судлан шийдвэрлэх санал боловсруулж, 2013 оны 9 сард багтаан Засгийн газарт оруулахыг Зам, тээврийн сайд А.Гансүхэд даалгав.	АЗБХЗГ
13	Зам, тээврийн яаманд 2015.04.06 №19	Х1.2."Иргэний нисэхийн үндэсний корпораци" ТАААТҮГ байгуулах ажлыг нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг алдагдуулахгүйгээр шуурхай зохион байгуулж, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүүд даалгав	БТГ



14	Зам, тээврийн яаманд 2015.09.21 №52	XI.Далай ашиглах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу "Монголын хөлөг онгоцны бүртгэл" компанийн үйл ажиллагааг шалгаж, дүрэм, журам болон хөлөг онгоц бүртгэх шалгуурыг боловсронгуй болгох, бүртгэлтэй хөлөг онгоцонд тавих хяналтыг чангатгах арга хэмжээ авч, энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусган боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр хойшлуулав.	БТГ ТЗУГ ТЗДТБХЗГ
15	Зам, тээврийн яаманд 2016.03.14 №15	ҮII.2. Олон улсын нисэх онгоцны шинэ буудал болон Богдхан уул орчим шинээр дагуул хот, төмөр замын ложистик төв, "Богдхан" төмөр зам, Алтанбулаг-Замын-Үүдийн хурдны авто зам барьж байгуулахад шаардлагатай газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг харилцан уялдаатай боловсруулж, шийдвэрлүүлж байхыг Зам, тээврийн сайд М.Зоригт, Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл, Төв аймгийн Засаг дарга Д.Баярбат нарт, улсын тусгай хэрэгцээнд авсан газарт батлан хамгаалахын зориулалттай барилга байгууламж байгаа эсэхийг судалж шийдвэрлэх арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Ц.Цолмонд тус тус даалгав.	ТЗДТБХЗГ АЗБХЗГ ХШУДАГ АТБХЗХ
16	Засгийн газрын гишүүдэд 2017.01.25 №4	ХҮIII.5. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2017-2018 оны улсын хэлэлцээрт үндэслэн аймаг, нийслэл, салбарын түвшинд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн хэлэлцээр байгуулах арга хэмжээ авч, хэрэгжилтийг ханган ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	ТЗУГ
17	Засгийн газрын гишүүдэд 2017.03.29 №14	2. Нисэх онгоцны шинэ буудлыг агаарын хөлгийн ТС-1 болон Жет А-1 төрлийн шатахуунаар хангах хос байгууламжтай болгох, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж байгаа Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид агаарын хөлгийн шатахуун шилжүүлэн ачих технологийн шугамын өргөтгөл хийх замаар Жет А-1 төрлийн шатахуун импортоор оруулах боломжийг бүрдүүлэх асуудлыг судлан хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгав.	АТБХЗХ ИНЕГ
18	Засгийн газрын гишүүдэд 2017.05.17 №22	4. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төрөөс олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог 3 дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасгах, давхардсан хяналт, шалгалт, хүнд суртлыг арилгах арга хэмжээний хүрээнд тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлаар ойрын хугацаанд төрийн болон ТББ, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдийн дунд хэлэлцүүлэг хийж, саналыг нь авч, холбогдох хуулийн төсөл боловсруулахыг МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат, холбогдох сайд нарт даалгав.	ТЗУГ
19	ЗТХЯ-д 2017.08.17 №36	7.6.УБ хотын олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаа, төслийн зээлийн захиран зарцуулалтад хяналт шалгалт хийх хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үр дүн, дүгнэлт, саналаа 2017.10.15-ны дотор ЗГ-т танилцуулахыг Сангийн сайд	БТГ ХШУДАГ АТБХЗХ



		Б.Чойжилсүрэн,ЗТХ-ийн сайд Д.Ганбат, БХБ-ын сайд Г.Мөнхбаяр нарт даалгав.	
20	Засгийн газрын гишүүдэд 2017.10.20 №44	11. Хот хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагааг улсын хэмжээнд хариуцаж байгаа АТҮТ ТӨҮГ-ын чиг үүрэгтэй давхацсан чиг үүрэгтэй, үр ашиггүй орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар байгуулсан шийдвэрээ хүчингүй болгох арга хэмжээ авахыг Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут, Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат нарт, энэ үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ЗТХ-ийн сайд Ж.Бат-Эрдэнэд тус тус даалгасугай.	АТБХЗГ